



Peace
Corps
MONGOLIA

АЖЛЫН ТАЙЛАН



ANNUAL
REPORT

2025



The Peace Corps Mission and Goals

The Peace Corps was first established in 1961 by U.S. President John F. Kennedy as a government agency that operates in different countries throughout the world at the request of those countries' governments and based on its needs and requirements. The Peace Corps mission and three goals endure.



Mission

To promote world peace and friendship through community-based development and intercultural understanding.



Goals

1. To help the countries interested in meeting their need for trained people.
2. To help promote a better understanding of Americans on the part of the peoples served.
3. To help promote a better understanding of other peoples on the part of Americans.

Энх тайвны корпусын эрхэм зорилго болон зорилтууд

Энх тайвны корпусыг анх 1961 онд АНУ-ын Ерөнхийлөгч Жон Ф. Кеннеди АНУ-ын Засгийн газрын агентлаг хэлбэрээр байгуулсан бөгөөд тухайн улсын засгийн газрын хүсэлт, тус орны хэрэгцээ шаардлагад үндэслэн дэлхийн олон оронд үйл ажиллагаа явуулдаг.

Энх тайвны корпусын эрхэм зорилго болон гурван үндсэн зорилтууд нь өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй хэвээр байна.



Эрхэм зорилго

Олон нийтийн оролцоонд суурилсан хөгжил болон соёлын харилцан ойлголцлоор дамжуулан дэлхийн энх тайван, найрамдлыг бэхжүүлэх.



Гурван үндсэн зорилго

1. Тухайн орны боловсон хүчний чадавхыг бэхжүүлэхэд туслах.
2. Тухайн орны ард түмэнд Америкийн ард түмнийг танин мэдэхэд нь туслах.
3. Америкийн ард түмэнд өөр өөрийн соёл, зан заншил бүхий бусад орнуудын ард түмнийг таньж мэдэхэд нь туслах.





Message from Peace Corps/Mongolia Country Director

What an honor and privilege it is for me to be back in Mongolia! Having served as a Volunteer in Hovsgul and as a member of the Peace Corps/Mongolia staff for five years, it's exciting to see continued community engagement and noticeable English language skills development.

I'm thankful for the sustained partnership on English education with the Ministry of Education and the General Authority for Education. I am also grateful for the warm welcome Peace Corps Volunteers receive from their schools and communities throughout the country.

It's through the passion, creativity, and hard work of so many school administrators, teachers, students and community members and the synergy with Peace Corps Volunteers that the Peace Corps is able to accomplish its goals. We are pleased to share some of these achievements in this annual report.

Lisa Powers, Country Director

Монгол дахь Энх тайвны корпусын орон хариуцсан захирлын мэндчилгээ

Монгол Улсад дахин томилогдон ирсэн нь миний хувьд нэр төрийн хэрэг, бахархалтай үйл явдал билээ. Анх Хөвсгөл аймагт сайн дурын ажилтнаар ирээд, үргэлжлүүлэн таван жил ажилласан юм. Арван жилийн дараа эргэн ирэхэд иргэдийн олон нийтийн оролцоо, англи хэлний үр чадвар зэрэг нь мэдэгдэхүйц сайжирсныг харахад үнэхээр сэтгэл хөдлөм байна.

Монгол Улсын Боловсролын яам болон Боловсролын ерөнхий газрын тогтвортой хамтын ажиллагаанд талархал илэрхийлье. Мөн Энх тайвны корпусын сайн дурын ажилтнуудыг үлс даяар сургуулиуд, олон нийтийн зүгээс халуун дотноор хүлээн авч байгаад гүнээ талархаж байна.

Энх тайвны корпусын зорилго нь сургуулийн удирдлагууд, багш, сурагч, олон нийтийн хүсэл тэмүүлэл, бүтээлч байдал, уйгагүй хөдөлмөр, сайн дурын ажилтнуудын хамтын ажиллагааны үр дүнд биелдэг. Бид энэхүү тайлангаараа эдгээр амжилтуудын заримаас та бүхэнтэй хуваалцахдаа баяртай байна.

Орон хариуцсан захирал Лиза Паувэрс

The History of Peace Corps in Mongolia

An intergovernmental agreement establishing the Peace Corps in Mongolia was signed on August 2, 1990 by Minister of Foreign Affairs of Mongolia Ts. Gombosuren and U.S. Secretary of State James Baker.

The first 25 Peace Corps Volunteers arrived in Ulaanbaatar on July 3, 1991.

Since 1991 about 1500 Volunteers have served in Mongolia, working with communities in Ulaanbaatar and throughout the country on English education, environment, health, business, non-government organizational development, and youth development activities.

English education has been the longest running program, interrupted only for a couple of years with the COVID pandemic.

Монгол дахь Энх тайвны корпус


Монгол Улсад Энх тайвны корпусыг байгуулах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрт Монгол Улсын Гадаад харилцааны сайд Ц.Гомбосүрэн, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Жеймс Бейкер нар 1990 оны 8-р сарын 2-ны өдөр гарын үсэг зурснаар үйл ажиллагаагаа эхлүүлж байжээ.

Анхны сайн дурын 25-н ажилтан 1991 оны 7-р сарын 3-нд Монгол Улсад ирснээс хойш 1500 орчим сайн дурын ажилтан нийслэл хот болон бүх аймаг, ихэнх сүмдэд англи хэлний боловсрол, байгаль орчин, эрүүл мэнд, бизнес, төрийн бус байгууллагын хөгжил, залуучуудын хөгжлийн чиглэлээр ажилласан байна.

“Англи хэлний боловсролын хөтөлбөр” нь хамгийн удаан хугацаанд үргэлжилж байгаа бөгөөд зөвхөн COVID цар тахлын үеэр түр завсарласан байдаг.

Mongolia Map and numbers of Volunteers by Aimag
(numbers as of December 2025)

Монгол дахь сайн дурын ажилтнууд
(2025 оны 12 дугаар сарын байдлаар)



Achievements in 2025 2025 оны ололт амжилтууд

Teachers and Students Who Participated in the English Education Program Англи хэлний боловсролын хөтөлбөрт хамрагдсан багш, сурагчид



424

English teachers worked with Volunteers.

Сайн дурын ажилтнуудтай хамтран ажилласан англи хэлний багш нарын тоо.



60%

of teachers reached increased the use of English in the classroom.

Багш нарын англи хэлний хэрэглээгээ нэмэгдүүлсэн хувь.



85%

of teachers reached increased capacity of teaching skills.

Багш нарын англи хэл заах ур чадвараа нэмэгдүүлсэн хувь.



9237

secondary school students reached through English teaching in the classroom.

Англи хэлний хичээлд хамрагдсан сурагчдын тоо.



87%

of students demonstrated improved English language abilities.

Сурагчдын англи хэлний чадвараа сайжируулсан хувь.

Youth Who Participated in Life-Skills Activities

Амьдрах ур чадварын үйл ажиллагаанд оролцсон залуус



2911

Youth who participated in life-skills related extra-curricular activities.

Амьдрах ур чадвартай холбоотой үйл ажиллагаанд оролцсон залуусын тоо.



87%

increased problem solving and decision-making skills.

Асуудал шийдвэрлэх болон шийдвэр гаргах ур чадвараа сайжруулсан хувь.



86%

increased their self-concept.

Өөрийн үнэлэмжийг нэмэгдүүлсэн хувь.



80%

increased social skills and communication.

Нийгмийн ур чадвар болон харилцааны чадвараа сайжруулсан хувь.

English Education and Community Development Program

Since 2022, Peace Corps/Mongolia has implemented the English Education and Community Development program based on the feedback and needs of the country, local communities, schools, Peace Corps Volunteers, and partnering agencies.



Program Goal

Students attain communication skills in English necessary to access academic and/or professional opportunities.



Program Objectives

1. Increase English language proficiency of English teachers.
2. Increase the capacity of English teachers to use general English and English teaching skills.
3. Increase student achievement and skills levels in English.
4. Increase community member capacity to design and manage a project to address identified community needs in English.

Англи хэлний боловсрол болон Хамт олон, Олон нутгийн хөгжлийн хөтөлбөр

2022 оноос Монгол Улс дахь Энх тайвны корпус нь Монгол Улсын болон орон нутгийн хэрэгцээ, санал хүсэлт, сургуулиуд, сайн дурын ажилтнууд болон хамтрагч байгууллагуудын шаардлагад үндэслэн “Англи хэлний боловсрол болон хамт олон, орон нутгийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.



Хөтөлбөрийн зорилго

Сурагчдад академик болон мэргэжлийн түвшинд хүрэхэд шаардлагатай англи хэлний харилцааны үр чадварыг эзэмшүүлэх.



Хөтөлбөрийн зорилтууд

1. Англи хэлний багш нарын англи хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх.
2. Багш нарын англи хэлний хэрэглээ болон англи хэл заах үр чадварыг дээшлүүлэх.
3. Сурагчдын англи хэлний мэдлэг, үр чадварын түвшинг ахиулах.
4. Орон нутгийн иргэдийн англи хэлний чадварыг дээшлүүлэх, тэдний хэрэгцээ шаардлагад нийцсэн төсөл хөтөлбөрийг төлөвлөж, удирдан хэрэгжүүлэх чадавхыг нэмэгдүүлэх.



Classroom Collaboration, Ulaanbaatar

Rafel S.

Rafel highlights his work with his counterparts as one of the most meaningful parts of his service. Together, they have co-taught, adapted lessons, and introduced IT tools like Kahoot to make learning interactive. Several English teaching counterparts became the founding members of the International Society (ISOC) of Mongolia. Their leadership and exposure to global digital initiatives are already having a positive impact on the school's evolution, encouraging innovation, confidence, and a forward-looking approach to education.

Ангийн хамтын ажиллагаа, Улаанбаатар

Рафел С.

“Түүний ажлын хамгийн үнэ цэнэтэй чухал хэсэг нь хамтрагч багш нартайгаа үр бүтээлтэй ажиллах юм” гэж Сайн дурын ажилтан Рафел онцоллоо. Тэд хамтран хичээл заах, хичээлийн агуулгыг тохируулан боловсруулах, мөн Kahoot зэрэг мэдээллийн технологийн хэрэгслүүдийг ашиглан сургалтыг илүү сонирхолтой, идэвхтэй болгож байна. Рафелтай хамтран ажилладаг англи хэлний багш нар Монголын Олон Улсын Нийгэмлэг (ISOC)-т гишүүнээр элсэж, дэлхийн дижитал санаачилгуудтай танилцсан нь сургуулийн цаашдын хөгжилд эергээр нөлөөлж эхэлжээ. Энэ үйл ажиллагаа нь манлайлал, итгэлтэй байдал, боловсролын хөгжил, ирээдүйд чиглэсэн хандлагыг төлөвшүүлэхэд дорвитой хувь нэмэр оруулж байна.



“Through our teamwork with Rafel in the classroom, I gained new skills and confidence in using technology for teaching, and this experience has had a positive influence on both students and teachers at our school.”

Saraa, English Teacher

“Рафелтэй хамтран ажилласнаар би технологийг сургалтад ашиглах шинэ ур чадвар эзэмшиж, итгэлтэйгээр хэрэгжүүлдэг болсон. Энэ туршлага нь манай сургуулийн багш, сурагчдад эерэг нөлөө үзүүлсэн.”

Англи хэлний багш, Сараа



English Room Renovation, Arkhangai

Ally H.

Enkhjargal and Ally transformed a neglected room into a welcoming English space at our school. They raised money to buy furniture and decorations and launched an English library with donated books. Their goal is to create a vibrant, collaborative environment that fosters curiosity and long-term learning.

Англи хэлний өрөөний шинэчлэл, Архангай

Алли Х.

Энхжаргал, Алли нар сургуулийн ашиглагддаггүй өрөөг тав тухтай англи хэлний танхим болгон өөрчилжээ. Тэд хандивын аян зохион байгуулж, тавилга болон чимэглэл худалдан авах хөрөнгө босгосон бөгөөд англи хэлний номын санг байгуулсан байна. Тэдний зорилго нь сурагчдын сониуч занг дэмжсэн, хамтын ажиллагааг хөгжүүлсэн, урт хугацааны суралцах орчныг бүрдүүлэх явдал юм.



“Intellectual investment is more valuable than any material wealth. Working hand-in-hand with Peace Corps volunteers, I am honored to support local children in expanding their learning opportunities. Though this room is small, it holds big dreams. From here, many children will step into the world with knowledge, confidence, and hope for a brighter future.”

Enkhjargal O, Counterpart

“Оюуны хөрөнгө оруулалт нь аливаа материаллаг баялгаас илүү үнэ цэнтэй. Сайн дурын ажилтнуудтай гар нийлэн ажиллаж, орон нутгийн хүүхдүүдийн суралцах боломжийг өргөжүүлэхэд хувь нэмэр оруулж байгаадаа би баяртай байна. Энэ өрөө жижигхэн ч, том мөрөөдлийг тээж байна. Эндээс олон хүүхэд мэдлэг, итгэл, гэрэлтэй ирээдүйд тэмүүлэх болно.”

Хамтран ажиллагч багш, Энхжаргал О.

Competitive College Club, Ulaanbaatar

Allan S.

Through the Competitive College Club (CCC) program, sponsored by EducationUSA, Allan mentors Mongolian students applying to U.S. colleges. He guides them through all aspects of the university admissions process from standardized testing, essay writing, and in interviewing. Through this process, students develop critical thinking and academic skills to prepare them for success abroad.

Өрсөлдөөнт Коллежийн Клуб, Улаанбаатар

Аллан С.

Сайн дурын ажилтан Аллан EducationUSA-ийн ивээл дор хэрэгждэг “Өрсөлдөөнт Коллежийн Клуб” (CCC) хөтөлбөрийг хэрэгжүүлэн Америкийн их, дээд сургуульд элсэхээр бэлдэж буй Монгол оюутнуудад зөвлөгөө өгч, чиглүүлж байна. Тэрээр оюутнуудад элсэлтийн стандартчилсан шалгалт өгөх, эссэ бичих, ярилцлагад оролцох зэрэгт тусалдаг. Ингэж бэлтгэснээр оюутнуудын бүтээлчээр сэтгэх болон академик үр чадвар хөгжиж, гадаадад амжилттай суралцахад дөхөм болдог.



“The classes were fun and interesting as well. I am looking forward to more classes related to university coursework. Overall, I think CCC was a nice program for me to prepare for the U.S colleges.”

Enerlee Ganzorig, Student

“Хичээлүүд сонирхолтой, хөгжилтэй байсан. Би их сургуулийн хөтөлбөртэй холбоотой илүү олон хичээлд хамрагдахыг тэсэн ядан хүлээж байна. Ерөнхийдөө, “Өрсөлдөөнт Коллежийн Клуб” (CCC) хөтөлбөр нь Америкийн их сургуулиудад элсэхэд маш хэрэгтэй гэж бодож байна.”

Оюутан, Энэрэлээ Ганзориг



The Toughest Job You'll Ever **Love**





Career Club, Dornogobi Aimag

Rwanda J. and Topher L.

Two Volunteers, Rwanda and Topher, ran a weekly Career Club for 7th-9th graders to explore diverse job options through interactive activities. Students have explored practical careers such as bank teller, airline workers, and paramedics, as well as creative roles such as fashion designers, translators, and entrepreneurs. The club has helped students plan their futures and reduce stress about career choices as they approach upper grades.

Карьер Клуб, Дорноговь аймаг

Руанда Ж. болон Тофер Л.

Сайн дурын ажилтан Руанда болон Тофер нар 7-9-р ангийн сурагчдад зориулан долоо хоног бүр “Карьер Клуб” (ажил мэргэжлийн чиг баримжаа олгох)-ыг зохион байгуулж, олон төрлийн мэргэжлийг интерактив хэлбэрээр судлах боломжийг олгож байна. Сурагчид банкны теллер, нислэгийн ажилтан, түргэн тусламжийн ажилтан зэрэг практик мэргэжлүүдээс гадна загвар зохион бүтээгч, орчуулагч, бизнес эрхлэгч зэрэг бүтээлч чиглэлүүдийг судалжээ. Энэхүү клуб нь сурагчдад ирээдүйн төлөвлөгөөгөө боловсруулахад тусалж, ахлах анги руу шилжих үед мэргэжлийн сонголттой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байна.





University Prep Club, Khovsgul

Keenan K.

At the request of his school administration, Keenan has advised a growing cohort of students with aspirations to study abroad. Relying on his own experience of navigating the complicated process of preparing for and applying to university, Keenan has conducted workshops and established a university prep club where he guides students through essay writing, program research, and setting realistic goals. Several of his students have already received admissions offers. Keenan's aim is to build lasting knowledge-sharing networks among students for years to come.

Их сургуулийн бэлтгэл клуб, Хөвсгөл

Кинан К.

Сайн дурын ажилтан Кинан сургуулийн захиргааны хүсэлтээр гадаадад суралцах хүсэлтэй сурагчдад зөвлөгөө өгч байна. Тэрээр өөрийн туршлага дээр тулгуурлан, их сургуульд элсэхэд шаардлагатай үйл явцын тухай семинар зохион байгуулж, эссэ бичих, хөтөлбөр судлах, бодит зорилго тавих зэрэгт чиглэсэн сургалттай клубыг зохион байгуулжээ. Түүний удирдлагад суралцсан хэд хэдэн сурагч аль хэдийн элсэлтийн үрилга хүлээн авсан байна. Кинаны зорилго нь мэдлэг, туршлагаа харилцан солилцдог сурагчдын тогтвортой сүлжээг бий болгох юм.



"I hope that the students I work with will come out of their college application journeys with concrete plans for pursuing their academic and professional aspirations as well as a deeper understanding of themselves."

Keenan K., Peace Corps Volunteer

"Миний хамтран ажиллаж буй сурагчид их сургуулийн элсэлтийн процессоо дуусгаад, академик болон мэргэжлийн зорилгоо хэрэгжүүлэх тодорхой төлөвлөгөөтэй, өөрсдийгөө илүү гүнзгий ойлгосон байгаасай гэж би хүсдэг."

Сайн дурын ажилтан, Кинан К.



Youth Waves 4, Bayankhongor

Kaitlyn M.

In October, counterpart Dashdulam O. and Kaitlyn hosted Youth Waves 4 at their school, a student-led public speaking showcase. This event was organized in partnership with BookBridge in Arvaikheer. Attendance at last year's event gave students the confidence and skills to plan and lead Youth Waves 4 in Bayankhongor.

Forty student speakers from Bayankhongor and Arvaikheer participated. Throughout the event, students demonstrated strong initiative. They resolved small issues related to timing, welcomed guests professionally, and ensured smooth transitions between speakers. The most significant outcomes were student leadership, strengthened public speaking skills, building community connections, and clear sustainability for future years. Students expressed interest in expanding Youth Waves next year.

Youth Waves 4, Баянхонгор

Кэйтлин М.

Аравдугаар сард Кэйтлин болон түүний хамтран ажиллагч О.Дашдулам нар сурагчдын илтгэлийн “Youth Waves 4” арга хэмжээг өөрийн сургууль дээрээ амжилттай зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээг Арвайхээр хотын BookBridge байгууллагатай хамтран зохион байгуулжээ. Өнгөрсөн жилийн арга хэмжээнд оролцсон сурагчид илүү итгэлтэй, үр чадвартай болсон нь Баянхонгор аймагт “Youth Waves 4”-ийг амжилттай төлөвлөж, удирдан зохион байгуулах боломжийг бүрдүүлжээ.

Баянхонгор аймаг болон Арвайхээр хотоос нийт 40 сурагч, илтгэгч оролцлоо. Сурагчид цагийн хуваарьтай холбоотой жижиг асуудлуудыг шийдвэрлэх, зочдыг мэргэжлийн түвшинд угтах, илтгэгч хоорондын шилжилтийг жигд хангах зэрэг олон санаачилгуудыг гаргасан. Хамгийн чухал үр дүн нь сурагчдын манлайлал, илтгэх үр чадварын ахиц, хамтын холбоо бий болгох явдал байлаа. Сурагчид ирэх жил “Youth Waves”-ийг өргөжүүлэх сонирхлоо илэрхийлсэн байна.

Track and Field Team, Orkhon

Max C.

With his background as a college athlete, Max assists in coaching the Orkhon Track and Field Team where teenagers and young adults meet to exercise, learn running techniques, and compete with other Mongolians in races. This activity promotes exercise, communication, leadership, time-management, problem-solving, goal-setting, and teamwork.

Хөнгөн атлетикийн баг, Орхон

Макс С.

Коллежийн багийн тамирчин байсан Макс Орхон-Уул аймгийн хөнгөн атлетикийн багийн дасгалжуулалтад тусалж байна. Энд өсвөр насныхан болон залуучууд цуглаж, дасгал хийж, гүйх техник эзэмшиж, Монгол Улсын бусад тамирчидтай өрсөлдөнө. Багийн бэлтгэл нь дасгал хөдөлгөөн, харилцаа, манлайлал, цагийн менежмент, асуудал шийдвэрлэх, зорилго тавих, багийн ажиллагаа зэргийг сайжруулдаг.



"These kids are incredibly passionate about track and field, so being able to provide them with the tools to pursue their passion and watch them succeed has been the most rewarding thing I've done during my Peace Corps service."

Max C. Peace Corps Volunteer

"Эдгээр хүүхдүүд хөнгөн атлетикийн спортод үнэхээр дуртай. Тэдний хүсэл тэмүүлэлдээ хүрэхэд нь хэрэгтэй техник, арга барилд сургаж, амжилтад хүрч буйг харах нь Энх тайвны корпусын сайн дурын ажлын минь хамгийн үнэ цэнтэй зүйл байлаа."

Сайн дурын ажилтан, Макс С.





Ikh Bogd Uul Partnership, Bayankhongor

Jon D.

Jon, as well as Einar, Henry, Katlyn, Paw and Terry, partnered with Ikh Bogd Uul National Park in Bayankhongor Province to support conservation and local development. The Volunteers launched an English language program to build the English language skills of staff and rangers, organized a science fair for university students, and prepared a sister park application to the U.S. National Parks program all while promoting the park's unique heritage, including the Ikh Bogd holy mountain and snow leopard habitat.

Их Богд уул - Хамтын ажиллагаа, Баянхонгор

Жон Д.

Жон болон Эйнар, Хенри, Кэйтлин, Пау, Терри нар Баянхонгор аймгийн Их Богд уулын байгалийн цогцолборт газрын захиргаатай хамтран байгаль хамгаалал болон орон нутгийн хөгжлийг дэмжих ажлыг хэрэгжүүлж байна. Сайн дурын ажилтнууд маань, байгаль хамгаалагчдын англи хэлний үр чадварыг дээшлүүлэх хөтөлбөр эхлүүлж, оюутнуудад зориулсан шинжлэх ухааны үзэсгэлэн зохион байгуулж, АНУ-ын Үндэсний паркуудтай “Эгч дүү парк” болох өргөдлийг бэлэн болгожээ. Мөн тэд Их Богд уул болон цоохор ирвэсийн амьдрах орчныг багтаасан паркийн өвөрмөц өвийг сурталчилж байна.



“Since beginning work with Ikh Bogd’s Special Protected Areas office we’ve been able to implement several projects that have been an absolute joy to work on with the team. Highlights have included running a science camp with the local Polytechnic College which will continue as weekly seminars at their campus. We have collected data and worked with the Snow Leopard Conservation Foundation and local herders to reduce the number of attacks on livestock within special protected areas. None of these accomplishments would be possible without the support and enthusiasm of our Ikh Bogd counterparts.”

Jon D., Peace Corps Volunteer

“Их Богдын тусгай хамгаалалттай газрын захиргаатай хамтран ажиллаж эхэлснээс хойш бид үнэхээр таатай олон төслийг амжилттай хэрэгжүүлсэн. Онцлох ажлуудад орон нутгийн Политехникийн коллежтой хамтран шинжлэх ухааны зуслан зохион байгуулсан бөгөөд энэ нь цаашид долоо хоног бүр семинар хэлбэрээр үргэлжлэх болно. Мөн бид мэдээлэл цуглуулж, Цоохор ирвэс хамгаалах сан болон орон нутгийн малчидтай хамтран тусгай хамгаалалттай газарт малд халдах тоог бууруулах арга хэмжээ авсан. Эдгээр амжилтууд нь Их Богд дахь хамтрагчдын дэмжлэг, идэвх зүтгэлгүйгээр боломжгүй байсан юм.”

Сайн дурын ажилтан, Жон Д.

Community Park Project, Ulaanbaatar

Jason B. and Devor R.

This year, Devor and Jason partnered with OneSky Mongolia and the local government in Ulaanbaatar to transform a ger district site into a community park that integrates early childhood principles. They have focused on planning, community workshops, and Volunteer coordination to ensure sustainability. Once complete, the park will provide families with safe play spaces and access to education and social services.

Цэцэрлэгт хүрээлэнгийн төсөл, Улаанбаатар

Жэйсон Б. болон Девор Р.

Энэ жил Девор болон Жэйсон нар OneSky Mongolia болон Улаанбаатар хотын захиргаатай хамтран гэр хорооллын хэсэг газрыг бага насны хүүхдүүдэд зориулсан цэцэрлэгт хүрээлэн болгон өөрчлөх ажлыг эхлүүлсэн. Тэд тогтвортой байдлыг хангахын тулд төлөвлөлт, олон нийтийн семинар, сайн дурынхны зохион байгуулалтад анхаарч ажиллаж байна. Төсөл дууссаны дараа уг цэцэрлэгт хүрээлэн нь гэр бүл, хүүхдүүдэд аюулгүй тоглох орчин, боловсрол болон нийгмийн үйлчилгээний хүртээмжийг бий болгоно.





Felt City Tours, Ulaanbaatar

Devor R.


Felt City Tours, a GerHub initiative, works with residents of Ulaanbaatar's ger districts to lead authentic cultural tours that provide income and showcase local life. Devor's engagement with this project has included refining storytelling, marketing, and youth training models. The project aims to strengthen community leadership and create sustainable livelihoods while giving tourists a genuine understanding of ger district life.

Эсгий хотын аялал, Улаанбаатар

Девор Р.

“Эсгий хотын аялал” нь хотын гэр хорооллын оршин суугчидтай хамтран соёлын аялал зохион байгуулж, гэр хорооллын амьдралтай танилцуулж, орлогын эх үүсвэр бий болгох GerHub байгууллагын санаачилга юм. Девор энэ төсөлд оролцон тайлбар түүх ярих арга барилыг сайжруулах, маркетинг, залуучуудын сургалтын загварыг боловсронгуй болгох ажлыг хийжээ. Төслийн зорилго нь олон нийтийн манлайллыг бэхжүүлэх, тогтвортой амьжиргааг бий болгох бөгөөд жуулчдад гэр хорооллын амьдралын талаар бодит ойлголт өгөх явдал юм.





Change Through Design, Dornod

Lauren H.

With a background in industrial design, Lauren naturally looks for new ways to rethink how we interact with the objects and environments around us. In Dornod, she found a great fit by partnering with local businesses and government to redesign a residential walkway. Aligned with UN Sustainable Development Goals, the project will incorporate green space, a small stage, and seating. In collaborating with local construction teams, architects, and city planners they are ensuring that the design reflects what the community needs. Construction is set to begin in 2026.

Дизайнаар дамжуулан өөрчлөлт хийх, Дорнод

Лорен Х.

Үйлдвэрлэлийн дизайны туршлагатай Лорен хүрээлэн буй орчин, орчны зохион байгуулалтыг хэрхэн сайжруулж, дахин зохион байгуулах шинэ арга замыг байнга эрэлхийлдэг. Дорнод аймагт тэрээр орон нутгийн бизнес эрхлэгчид болон төрийн байгууллагуудтай хамтран орон сууцны явган замыг дахин загварчлах төслийг хэрэгжүүлж байна. НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн уг төсөлд ногоон байгууламж, жижиг тайз болон үзэгчдийн суудал багтах юм. Орон нутгийн барилгын баг, архитекторууд, хот төлөвлөгчидтэй хамтран ажилласнаар уг төсөлд олон нийтийн хэрэгцээг бүрэн тусгахыг зорьж байна. Барилгын ажил 2026 онд эхлэхээр төлөвлөгджээ.



Peace
Corps
MONGOLIA



ᠮᠣᠩᠭᠣᠯᠢ ᠠᠨᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠨ ᠠᠨᠠᠭᠤᠯᠤᠯᠤᠰ

- 🌐 www.peacecorps.gov/mongolia
- 📘 Peace Corps Mongolia
- ✉ ms-its@peacecorps.gov
- 📞 [+1 202 462 2200](tel:+12024622200)
- 📍 Central P.O. Box 1036, Ulaanbaatar 15100, Mongolia